

ХБТХОХ-ИЙН БАРИЛГА ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Р.ГАЛБААТАРЫН
2024 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
Зорилт 1. НЭГ. “АЙМГИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:							
Зорилт 8.3. Хотын хэсэгчилсэн болон ерөнхий төлөвлөгөөг төлөвлөж, зам харилцаа, инженерийн дэд бүтэц байгуулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлж, хотын соёлыг төлөвшүүлнэ:							
1.	Арга хэмжээ 1.1.						
2	1.1. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулах	Ажлын даалгаврыг боловсруулсах	Төлөвлөгөөний төсөв	Төсөв санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн байна.	Орхон аймгийн “Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулах ажилд Эдийн засаг, хөгжлийн сайдын багцаас 1,3 тэрбум төгрөгийн төсөв батлагдаж, уг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын даалгаврыг шинэчлэн боловсруулахад орон нутгийн холбогдох байгууллагууд саналаа нэгтгэн тусгаж БХБЯамд хүргүүлэн 2024 оны 05-р сарын 22-ны өдөр Барилга, хот байгуулалтын сайд 2024/07 дугаартай даалгаврыг батласан. БХБЯамнаас гүйцэтгэгч байгууллага сонгон шалгаруулах үйл ажиллагааг 2 удаа зохион байгуулан 2024 оны 10 сарын 31-нд “Нью урбанизм” ХХК шалгарч 8 сарын хугацаанд гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажиллаа эхэлсэн.	2024-01-01 2024-12-31	90%
3	1.2.Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг үе шаттай сурталчлах ажлыг зохион байгуулах	Сурталчилгаа хийгдсэн байна.	2023 онд 7520 иргэн мэдээлэл авсан байна	Иргэдийн мэдээлэл сайжирна.	Баян-Өндөр болон Жаргалант суманд зохион байгуулсан “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгөөр Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон Жаргалант сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг зурагт самбар, альбом хэлбэрээр сурталчилж. 840	2024-01-01 2024-12-31	70%

130

					гаруй иргэнд танилцуулсан. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөлтүүдийг /https://erdenet.gazar.gov.mn/ цахим хуудаст байршуулж иргэдэд мэдээлснээр тайлангийн хугацаанд давхардсан тоогоор нийт 13280 иргэн мэдээлэл авсан байна. "Эрдэнэ шинэ илгээлт 50" төслийн хүрээнд "Төлөвлөлттэй хот" танилцуулгыг Амарын талбайд 2024.09.17-оос хойш 7 хоногийн хугацаанд Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар иргэдэд танилцуулах ажлыг зохион байгуулсан.		
4	1.3.Дахин төлөвлөх үйл ажиллагааг олон нийтийн оролцоотой зохион байгуулж, төлөвлөлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж хүлээн авах	Зургийг боловсруулж батлуулсан байна.	Төлөвлөлтийн зураг төсөл 90 хувийн гүйцэтгэлтэй боловсруулагдаж байна.	Дахин төлөвлөлтийн ажил эхэлсэн байна	Аймгийн хэмжээнд Цагаанчулуут багт 11.9 га, Уурхайчин багт 1.3 га газарт дахин төлөвлөлтийг хийж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар тогтоолоор батлуулсан. Тус тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Уурхайчин багт 1.3 га газарт дахин төлөвлөлтийн ажил гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулан төсөл эхлүүлснээр хэрэгжилт 30 хувьтай, Цагаанчулуут багт 11.9 га талбайд дахин төлөвлөн барилгажих хэсэгчилсэн төлөвлөлтийн зураг төсөл хийгдэж байна. Дахин төлөвлөх үйл ажиллагааг мэргэжлийн байгууллаагаар хийлгэх ажлын хүрээнд Эрдэнэ багт 2.5 га талбайд дахин төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулан сонгон шалгаруулалт зарласан. Оюут багийн Сархиа уулын энгэрт 4 га талбайд 300 айлын амины орон сууцны төслийг хэрэгжүүлэхээр суурь судалгааны ажил хийгдэж байна. Баян-Өндөр	2024-01-01 2024-12-31	100%

					сумын Хүрэнбагт Уурхайчин-1 хорооллын баруун талд амины болон цөөн давхар барилгын хэсэгчилсэн төлөвлөлтийг 10га талбайд хийлгэж байгаа ба зураг төсөл боловсруулах ажил 40 хувийн гүйцэтгэлтэй байна.		
5	1.4. Инженерийн хангамжтай нийтийн болон амины орон сууцны хорооллуудыг барьж аймгийн орон сууцны санг нэмэгдүүлэх	Инженерийн хийцлэлтэй орон амины орон сууцны тоо	Зураг төсөл төсөл сонгон шалгаруулалт зарлагдсан	Амины орон сууцны иж бүрэн зураг төсөлтэй болсон байна.	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгө оруулалтаар 400 айлын "Уурхайчин-3" амины орон сууцны хорооллын барилга угсралтын ажил 60 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Мөн хувийн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээнд нийтийн орон сууцны 863 айлын 15 төсөл Оюут, Цагаан чулуут, Найрамдал, Зэст багуудад тус тус баригдаж байгаагаас одоогийн байдлаар 568 айлын орон сууц ашиглалтанд орсон	2024-01-01 2024-12-31	100%
6	1.5. Инженерийн хангамжтай нийтийн орон сууцны хорооллуудыг гэр хорооллын багуудад барьж аймгийн орон сууцны санг нэмэгдүүлэх	Уртын гол багт шинээр орон сууц барилга угсралтыг ажлын хувь	80 хувь	5 блок, 260 айлын орон сууцны ажлын гүйцэтгэл 80 хувь	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар "Орон сууцны хөтөлбөр"-ийг батлуулан Баян-Өндөр сумын Уртын гол багт 260 айлын 5 блок орон сууцны барилгын ажлыг 2022 оноос эхлүүлсэн. Тус барилгын төсөвт өртөг нь 27.4 тэрбум төгрөг байна. Тус барилгад 2021 онд 3.0 тэрбум, 2022 онд 13.1 тэрбум, 2023 онд 3.8 тэрбум төгрөг, нийт 19.9 тэрбум төгрөгийн санхүүжилтыг олгон ажилласнаар одоогийн байдлаар тус 5 блок барилгын А блок улсын комисс ажиллан дахин ажиллуулахаар болсон, Е блок 12 хувийн гүйцэтгэлтэй, В, С, D блок ажил бүрэн дуусч ашиглалтад хүлээлгэн өгснөөр тус төсөл 82 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Одоогийн байдлаар ашиглалтанд орсон 3 блок барилгад нийт 100 айл орсон. Төслийн хүрээнд Ус дулаан дамжуулах төв, цахилгааны дэд өртөөний барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулсан.	2024-01-01 2024-12-31	100%

7	1.6. Хот доторх авто зам, явган хүний зам болон дугуйн зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдрах орчныг сайжруулах	Иргэдийн амьдрах орчныг сайжрах	-	Иргэдийн амьдрах орчныг сайжруулах	50 тэрбумын хөрөнгө оруулалтаар 50 байршилд авто зам замын байгууламжийн ажил гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна. Үүнээс Шинээр хийх 8.3 км авто замд 21.9 тэрбум, 5 байршилд шинээр авто зогсоол хийх ажилд 1,4 тэрбум төгрөг, хотын доторх 23.3 км авто замын их засвар шинэчлэлтийн ажилд 25.6 тэрбум төгрөг, тэмдэг тэмдэглэгээний ажилд 910 сая төгрөгийг зарцуулахаар орон нутгийн төсөвт батлаад байна. Тус ажлуудаас 16 ажлийн зураг төсөв Зам тээврийн хөгжлийн төвийн магадлалын ерөнхий дүгнэлт гарч худалдан авах ажиллагааг зохион байгуулан 46 ажилд гүйцэтгэгч шалгаран гэрээ байгуулах ажил хийгдэж байна. 33 ажил дуусч комисс хүлээн авсан.	2024-01-01 2024-12-31	100%
8	1.7. Барилга байгууламжийн ашиглалтын төлөв байдалд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, паспортжуулах ажлыг үе шаттай зохион байгуулах	Шинээр ашиглалтад орсон 27 барилгыг паспортжуулж гэрчилгээ олгосон.	Орон сууцны 11, төрөл бүрийн зориулалтай олон нийтийн 9, сургууль цэцэрлэгийн барилга 2, инженерийн шугам сүлжээ 5 нийт 27 барилга ашиглалтад орж паспортжуулсан.	Ашиглалтад орсон барилга байгууламжийг, паспортжуулсан байна	Барилга байгууламжийн ашиглалтын төлөв байдалд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, паспортжуулалт гэрчилгээжүүлэх ажлын даалгаврыг боловсруулан Аймгийн Засаг даргаар батлуулж худалдах, худалдан авах ажиллагаа хийгдэж байна. Энэхүү ажлын даалгаварт Жаргалант сумын сургууль, цэцэрлэгийн Барилга байгууламжийн ашиглалтын төлөв байдалд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, паспортжуулах ажлын зөвлөл, хөрөнгө оруулалтаас шалтгаалан хэрэгжилтгүй байна. 2023 онд Барилга байгууламжийг паспортжуулах ажлын даалгаврыг боловсруулан Аймгийн Засаг даргаар батлуулж худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Барилга байгууламжийн ашиглалтын төлөв байдлын хяналтаар:	2024-01-01 2024-12-31	100%

					Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн хичээлийн 1 дүгээр байрны ашиглалтын хугацаа дуусч, газар хөдлөл, байгалийн хүчин зүйлийн нөлөөнд нурах эрсдэлтэйг үнэлэн тогтоосон. Ерөнхий боловсролын 14 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилгын карказ байгалийн хүчин зүйлийн нөлөөнд нурах эрсдэлтэйг үнэлэн тогтоосон Жаргалант сумын Сургууль, цэцэрлэгийн барилгын буурь суурь сууж, даацын болон даацын бус хананд 3-4 хэсэгт нэвт цууралт үүссэн Нийтийн зориулалттай орон сууцны барилга 2-23, 2-25, 4-20, 4-26, 4-27 байруудын буурь суурь сууж, үндсэн даацын хийцэд хэв гажилт үүссэн. 2024 онд Аймгийн хэмжээнд баригдаж байгаа барилга байгууламжид БХБЯ-ны 02-00/08 удирдамжаар урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, 3 ААНБ-д 30 сая, 8 иргэнд 8 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч барилга угсралтын ажил зогсоох акт 2, илэрсэн зөрчлийг арилгуулах албан шаардлага 16, дүгнэлт 4, зөвлөмж 25 гаргаж хэрэгжилтийг хангуулан ажилласан..		
9	1.9. Аймгийн хэмжээнд баримтлах салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, хөтөлбөр, төслийг хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй уялдуулан боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах.	Аймгийн хэмжээнд баримтлах салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, хөтөлбөр, төслийг хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй уялдуулан	2023 онд төлөвлөгөөнд 38.5 тэрбум төгрөгийн 176 ажил төлөвлөгдөн хийгдсэн.	Хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлагнасан байна.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээнд хэрэгжиж байгаа 17 төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавин батлагдсан маягтын дагуу Барилга хот байгуулалтын яаманд тайлагнан ажилласан. Мөн он дамжин хийгдэж байгаа сургууль гурван, соёлын төвийн нэг, тусгай зориулалтын нэг барилга байгууламжид хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гаргуулах ажилыг зохион байгуулсан. Тус төсөл	2024-01-01 2024-12-31	100%

		боловсруулсан байна.			арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай үлдэгдэл санхүүжилтыг тооцоолон 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд санал хүргүүлсэн.		
10	1.11. Барилга, хот байгуулалтын чиглэлийн бодлого, төлөвлөлт, зохицуулалтыг орон нутагт хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах.	Барилгын салбарын бодлого, төлөвлөлт, зохицуулалтыг орон нутагт хэрэгжүүлэх, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.		Барилга, хот байгуулалтын бодлого, төлөвлөлт, зохицуулалтыг орон нутагт хэрэгжүүлэн ажиллана.	Барилга хот байгуулалтын яамнаас ирүүлсэн Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах албан даалгаврын хүрээнд ажлын хэсэг байгуулан шинээр баригдаж байгаа 23 барилга байгууламжид үзлэг шалгалт хийсэн. Шалтгалтын хүрээнд зөвшөөрөлгүй барилга угсралтын ажил эхэлсэн 5 барилга хуулийн хүрээнд арга хэмжээ авах ажлыг зохион байгуулан зөрчлийг арилгуулан ажилласан.	2024-01-01 2024-12-31	100%
11	1.12. Бодлогын баримт бичиг, аймгийн Засаг даргаас салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.	Бодлогын баримт бичиг, аймгийн Засаг даргаас салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.	Хэрэгжилт 95,5 хувь	Бодлогын баримт бичиг, аймгийн Засаг даргаас салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэж тайланг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.	Барилга хот байгуулалтын яамтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт хийж биелэлтийг хагас жилийн байдлаар гаргаж 94 хувьтай үнэлэгдсэн.	2024-01-01 2024-12-31	100%
12	1.13. Хот багуулалтын чиглэлээр шаардлагатай зураг төслийн ажиллуудад зураг төсөл боловсруулах даалгавар боловсруулах	Боловсруулан даалгаварын тоо	9даалгавар боловсруулсан	Ажлын даалгавар боловсруулсан байна.	Говил болон Баянбулаг багт баригдах УДДТ, Яргуйт, Баян- овоот багийн захиргааны барилга, цэцэрлэгийн барилгуудыг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр халаах зураг төсөл боловсруулах ажил, орхон аймаг, баян-өндөр сум доторх авто зам, зогсоол, үерийн усны	2024-01-01 2024-12-31	100%

					байгууламжийн зураг төсөл боловсруулах ажил, даалгаврууд зэрэг 56 даалгавар боловсуулан батлуулсан.		
13	1.14. Салбарын чиглэлээр иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, хариу мэдэгдэх	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь	Өргөдөл гомдлын 78-ийг шийдвэрлэсэн.	Өргөдөл гомдлыг хүлээн авч судлан шийдвэрлэж хариу хүргүүлсэн байна.	Салбарын чиглэлээр иргэдээс 70 өргөдөл, 85 албан хүсэлтээс 134 албан хүсэлтийг хуулийн хүрээнд шийдвэрлэсэн ажилласан. Мөн тайлант жилийн хугацаанд 90 үүрэг даалгавар удирдлагааг өгсөнийг шийдвэрлэсэн.	2024-01-01 2024-12-31	100%
14	1.15. Салбарын чиглэлийн хууль, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах	Төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн ажилласан байна.	Төлөвлөгөөний төсөв	-	Хөрөнгө оруулалтын ажлын "Нээлттэй хаалганы өдөр"-ийг 2024 оны 05 дугаар сарын 24 - өдөр Амарын талбайд зохион байгуулж хот байгуулалтын "urban.gov.mn" цахим систем барилга угсралтын ажлыг эхлүүлэх болон үргэлжлүүлэх зөвшөөрөл авахад шаардлагатай баримт бичгийн хэвлэмэл хуудсыг 120 ширхэгийг тараан мэдээлэл хүргэсэн байна. Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд санал хүргүүлсэн.	2024-01-01 2024-12-31	100%
15	1.16. Барилга хот байгуулалтын салбарын чиглэлээр холбогдох захирамжийг боловсруулан батлуулж ажиллах	Холбогдох захирамжийг гаргуулж, биелэлтэд хяналт тавин ажилласан байна.		Захирамжийн биелэлтэд хяналт тавин ажиллана.	Бүтээн байгуулалтын улирал эхэлж байгаатай холбогдуулан аймгийн хэмжээнд 2024 онд шинээр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудыг танилцуулах, сурталчлах, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах, барилга, авто замын материал үйлдвэрлэгч, аж ахуйн нэгжүүдийг олон нийтэд танилцуулах өдөрлөгийг захирамж батлуулан хэрэгжилтийн хангуулсан.	2024-01-01 2024-12-31	100%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/Д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.						
1	2.1.ТАХ-ийн төлөвлөгөө гүйцэтгэлийн боловсруулж	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний	ТАХ-ийн гүйцэтгэлийн	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний	ТАХ-ийн гүйцэтгэлийн боловсруулж	2024-01-01 2024-12-31	100%

	батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх;	хэрэгжилт, биелэлт, холбогдох албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна.	төлөвлөгөө хэрэгжүүлэх	хэрэгжилт, биелэлт, албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн холбогдох газарт хүргүүлсэн байна.	батлуулан, төлөвлөгөөний биелэлт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, тайлагнасан.		
2	2.2.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллана.	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	2024-01-01 2024-12-31	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1.							
1.	Арга хэмжээ 1.1.						
1	Шинээр батлагдсан хууль тогтоомжийг судалж, үйл ажиллагаандаа ашиглах, төрийн албаны тухай хуульд заасны дагуу багц сургалтад хамрагдсан байх	Хууль, эрх зүйн мэдлэгийг бие даан сайжруулсан байна.	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн эхний үе шат "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг зорилго		Салбарын болон холбогдох чиглэлээр хууль, эрх зүйн мэдлэгийг бие даан сайжруулан ажилласан.	2024-01-01 2024-12-31	100%

			зорилтыг төрийн албан хаагчдад таниулах сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан.			
2	Салбарын чиглэлээр холбогдох сургалтад хамрагдах	Шинэ мэдлэг, мэдээллийг бие даан сайжруулсан байна.	Сургалтад хамрагдсан.		Төрийн албаны салбар зөвлөл, сонгуулийн хорооноос зохион байгуулсан сургалт болон салбарын чиглэлээр зохион байгуулсан дөрвөн сургалтанд хамрагдсан.	2024-01-01 2024-12-31 100%
3	Үндэсний бичгийн сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан байх.	Сургалтад хамрагдсан.		Төрийн албанаас зохион байгуулж буй үндэсний бичгийн сургалтанд хамрагдсан.	2024-01-01 2024-12-31

ТАЙЛАН ГАРГАСАН:

Барилга, инженерийн шугам
сүлжээ хариуцсан ахлах
мэргэжилтэн

(Албан тушаал)

..... /Р.Галбаатар/
(Нэр, гарын үсэг)

2024-12-09

(Огноо)

09/12